



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Биеийн тамир спортын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/76/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170 Цахим хаяг: www.dalaivanaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	19

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.26 № 39

танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ДЭЛГЭРБАЯР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>70,561,882.18</u>	<u>83,385,936.20</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,552,000.00	752,000.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	2,552,000.00	752,000.00
3121	Төгрөг	2,552,000.00	752,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	2,552,000.00	752,000.00
33	АВЛАГА	465,824.74	14,056,630.74
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	262,806.00
335	Бусад авлага	465,824.74	13,793,824.74
3351	Байгууллагаас авах авлага	465,824.74	13,793,824.74
35	БАРАА МАТЕРИАЛ	67,544,057.44	68,577,305.46
351	Түүхий эд материал	60,860,781.00	61,153,881.00
35110	Тусгай зориулалттай материал	60,860,781.00	61,153,881.00
354	Хангамжийн материал	6,683,276.44	7,423,424.46
35410	Бичиг хэргийн материал	443,510.00	726,958.00
35420	Аж ахуйн материал	1,178,600.00	507,300.00
35440	Түлш, шатах тослох материал	-	920,000.00
35450	Барилгын засварын материал	3,457,666.44	3,862,166.46
35470	Бусад хангамжийн материал	1,603,500.00	1,407,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,134,264,280.57</u>	<u>6,999,738,372.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,134,264,280.57	6,999,738,372.13
392	Биет хөрөнгө	6,947,864,280.57	6,813,338,372.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,292,935,004.71	7,298,240,562.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	(634,480,364.75)	(774,993,808.85)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,600,000.00	72,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(32,709,999.92)	(35,509,999.94)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,800,635.00	36,300,635.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,804,567.31)	(26,611,614.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,210,699.50	92,215,339.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(59,611,009.28)	(64,078,603.32)

39209	Зам, гүрийн байгууламж	668,132,315.94	661,511,515.94
39210	Хуримтлагдсан элэгдэл	(430,208,433.32)	(445,935,654.28)
393	Биет бус хөрөнгө	186,400,000.00	186,400,000.00
39301	Программ хангамж	850,000.00	850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(850,000.00)	(850,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	186,400,000.00	186,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,204,826,162.75</u>	<u>7,083,124,308.33</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>545,073.11</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	545,073.11
413	Өглөг	-	545,073.11
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	545,073.11
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,204,826,162.75</u>	<u>7,082,579,235.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,204,826,162.75	7,082,579,235.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,158,797,849.34	5,158,797,849.34
512	Хуримтлагдсан үр дүн	371,569,919.86	249,322,992.33
51210	Өмнөх үеийн үр дүн	371,569,919.86	371,569,919.86
51220	Тайлант үеийн үр дүн	-	(122,246,927.53)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,674,458,393.55	1,674,458,393.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,204,826,162.75</u>	<u>7,083,124,308.33</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,145,118,195.00	610,968,208.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	357,063,995.00	47,178,508.00
120	Нийтлэг татварын бус орлого	356,318,995.00	47,178,508.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	356,318,995.00	47,178,508.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,781,500.00	8,192,950.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	338,317,495.00	38,985,558.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	788,054,200.00	563,789,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	156,788,000.00	194,244,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	147,425,000.00	178,025,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,924,000.00	15,620,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,289,500.00	599,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	439,542,600.00	369,545,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	369,692,600.00	369,545,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	707,903,408.64	733,215,135.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	707,903,408.64	733,215,135.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	649,974,833.17	638,091,057.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,804,128.32	280,671,421.23
210101	Үндсэн цалин	247,729,428.32	209,304,696.16
210102	Нэмэгдэл	-	60,524,384.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,074,700.00	10,842,341.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,412,802.87	35,790,194.01
210201	Тэтгэврийн даатгал	21,891,800.89	25,674,094.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,509,008.69	2,529,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,007,206.95	2,023,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	454,980.58	505,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,549,805.76	5,058,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,712,929.34	22,330,991.77
210301	Гэрэл, цахилгаан	6,853,781.21	5,114,007.84
210302	Түлш, халаалт	10,319,675.49	14,241,087.93
210303	Цэвэр, бохир ус	2,539,472.64	2,975,896.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,220,606.00	7,074,334.00
210401	Бичиг хэрэг	844,997.00	698,602.00
210402	Тээвэр, шатахуун	2,999,480.00	2,160,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,013,279.00	478,072.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	251,000.00	425,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,532,850.00	1,420,260.00
210408	Бараа материал акталсны зардал	17,573,500.00	1,892,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,723,150.00	2,470,479.98
210604	Урсгал засвар	14,903,150.00	2,470,479.98
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,183,550.00	8,090,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,880,300.00	4,577,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	1,460,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,250.00	125,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	470,000.00	1,611,600.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	298,741,766.64	281,662,686.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	142,355,220.00	108,231,220.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	156,386,546.64	173,431,466.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,928,575.47	95,124,078.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,521,200.00	74,404,035.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,643,700.00	32,837,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,877,500.00	41,566,735.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,407,375.47	20,720,043.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,407,375.47	20,720,043.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	437,214,786.36	(122,246,927.53)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	436,927,786.10	(122,246,927.53)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	544,332,600.00	571,982,650.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,001,500.00	8,192,950.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,001,500.00	8,192,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,001,500.00	8,192,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,781,500.00	8,192,950.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	526,331,100.00	563,789,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	156,638,500.00	194,244,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	146,926,500.00	178,025,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,924,000.00	15,620,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,788,000.00	599,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	369,692,600.00	369,545,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	369,692,600.00	369,545,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	530,090,645.00	573,782,650.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	530,090,645.00	573,782,650.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	469,407,069.53	465,538,571.90

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,570,728.32	280,934,227.23
210101	Үндсэн цалин	234,331,228.32	209,567,497.16
210102	Нэмэгдэл	9,902,700.00	60,524,389.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,336,800.00	10,842,341.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,412,802.87	35,790,194.01
210201	Тэтгэврийн даатгал	21,712,703.75	25,674,094.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,425,000.00	2,529,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,940,000.00	2,023,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	485,000.00	505,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,850,099.12	5,058,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,712,929.34	21,785,918.66
210301	Гэрэл, цахилгаан	6,853,781.21	4,568,934.73
210302	Түлш, халаалт	10,319,675.49	14,241,087.93
210303	Цэвэр, бохир ус	2,539,472.64	2,975,896.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,335,989.00	5,901,862.00
210401	Бичиг хэрэг	1,090,430.00	999,550.00
210402	Тээвэр, шатахуун	2,999,480.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,013,279.00	478,072.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	236,000.00	425,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	996,800.00	999,240.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,247,250.00	4,296,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,496,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	10,751,250.00	3,996,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,409,450.00	8,390,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,106,200.00	4,877,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	1,460,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,250.00	125,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	470,000.00	1,611,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	136,534,420.00	108,439,220.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,534,420.00	108,439,220.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,683,575.47	108,244,078.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,276,200.00	74,404,035.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,643,700.00	32,837,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,632,500.00	41,566,735.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,407,375.47	8,721,452.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,407,375.47	8,721,452.60

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	25,118,590.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,118,590.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>14,241,955.00</u>	<u>(1,800,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(393,000.00)	(1,800,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,945,000.00	2,552,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,552,000.00	752,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,158,797,849.34	1,674,458,393.55	195,284,733.76	7,028,540,976.65
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,158,797,849.34	1,674,458,393.55	195,284,733.76	7,028,540,976.65
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	176,285,186.10	176,285,186.10
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,158,797,849.34	1,674,458,393.55	371,569,919.86	7,204,826,162.75
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,158,797,849.34	1,674,458,393.55	371,569,919.86	7,204,826,162.75
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,158,797,849.34	1,674,458,393.55	371,569,919.86	7,204,826,162.75
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(122,246,927.53)	(122,246,927.53)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,158,797,849.34	1,674,458,393.55	249,322,992.33	7,082,579,235.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны Гүйцэтгэл	Тайлант оны	
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	531,135,997.53	384,548,500.00	369,016,697.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	516,501,042.53	384,548,500.00	369,016,697.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473,202,969.53	347,933,000.00	332,401,197.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,570,728.32	252,903,500.00	252,812,766.74
210101	Үндсэн цалин	234,331,228.32	199,595,300.00	181,446,036.67
210102	Нэмэгдэл	9,902,700.00	40,724,200.00	60,524,389.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,336,800.00	12,584,000.00	10,842,341.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,412,802.87	31,616,200.00	31,612,900.00
210201	Тэтгэврийн даатгал	21,712,703.75	21,496,800.00	21,496,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,425,000.00	2,529,000.00	2,529,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,940,000.00	2,024,300.00	2,023,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	485,000.00	505,800.00	505,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,850,099.12	5,060,300.00	5,058,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,712,929.34	21,213,300.00	21,085,918.66
210301	Гэрэл, цахилгаан	6,853,781.21	4,230,500.00	3,868,934.73
210302	Түлш, халаалт	10,319,675.49	13,982,800.00	14,241,087.93
210303	Цэвэр, бохир ус	2,539,472.64	3,000,000.00	2,975,896.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,335,989.00	6,340,000.00	5,901,862.00
210401	Бичиг хэрэг	1,090,430.00	1,000,000.00	999,550.00
210402	Тээвэр, шатахуун	2,999,480.00	3,000,000.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,013,279.00	840,000.00	478,072.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	236,000.00	500,000.00	425,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	996,800.00	1,000,000.00	999,240.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,043,150.00	4,300,000.00	4,296,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,496,000.00	300,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	10,751,250.00	4,000,000.00	3,996,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,700,000.00	1,485,200.00	-
210702	Дотоод албан томилолт	1,700,000.00	1,485,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,409,450.00	7,502,800.00	6,390,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,106,200.00	3,860,000.00	2,877,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	1,460,000.00	1,460,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,250.00	200,000.00	125,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	120,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	470,000.00	1,612,800.00	1,611,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	136,534,420.00	22,572,000.00	10,300,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,534,420.00	22,572,000.00	10,300,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,298,073.00	36,615,500.00	36,615,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,298,073.00	36,615,500.00	36,615,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,643,700.00	32,837,300.00	32,837,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,632,500.00	3,778,200.00	3,778,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	581,439,573.00	754,090,400.00	377,738,150.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	191,723,600.00	369,545,200.00	-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	81,486,000.00	369,545,200.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	369,692,600.00	369,545,200.00	369,545,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	369,692,600.00	369,545,200.00	369,545,200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	18,001,500.00	15,000,000.00	8,192,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,781,500.00	15,000,000.00	8,192,950.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	-	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	30.00	28.00
620001	Удирдах ажилтан	-	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	-	14.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	-	15.00	15.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	169,125,909.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	169,125,909.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	133,137,374.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,121,460.49
210101	Үндсэн цалин	28,121,460.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,177,294.01
210201	Тэтгэврийн даатгал	4,177,294.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	700,000.00
210301	Гэрэл, цахилгаан	700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,138,620.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,138,620.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,988,535.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,988,535.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,988,535.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	194,244,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	194,244,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	178,025,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,620,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	599,500.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир спортын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус газрын дарга Д.Дэлгэрбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 17-ноос 2021 оны 02 дугаар сарын 15-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК Орхон аймаг дахь салбарын захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн, туслах аудитор Б.Энхжин нар Орхон аймгийн төрийн аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Биеийн тамир спортын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймгийн төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 3/10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Орхон аймгийн Биеийн тамир, спортын газар нь Биеийн тамир, спортын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, таниулах, сурталчлах, дэмжлэг үзүүлэх, биеийн тамир, спортын бүх нийтийн оролцоог идэвхжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Орхон аймгийн Биеийн тамир спортын газрын 2020 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Спортын төрлийн секц, дугуйланд хамрагдагсдын нас, хүйсэнд бүртгэл, судалгаа хийх
- Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нийтийн биеийн тамир спортын арга хэмжээнд хамрагсдын тоог нэмэгдүүлэх
- Спортын заал, гадна талбайн тохижилтыг сайжруулах
- Спортын арга хэмжээнд хамрагсдын судалгаа, бүртгэл хийх
- Орон нутагт болж буй тэмцээн уралдааныг зохион байгуулах
- Дэлхий, тив, олон улс, улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт гаргасан тамирчдын бүртгэл, судалгаа хийх

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Биеийн тамир, спортын тухай хууль
- Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол

Тайлант хугацаанд гарсан онцлог өөрчлөлт, шинэчлэлт байхгүй.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн Биеийн тамир спортын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа хэдий ч байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ зэрэг нь 2017 оноос хойш шинэчлэгдээгүй байна.

Орхон аймгийн Биеийн тамир спортын газрын байгууллагын дотоод хяналтын комисс нь 2020 онд 14 зорилтын хүрээнд нийт 21 ажил төлөвлөсөн байна. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө батлагдсан боловч тайлангийн хугацаанд санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Орхон аймгийн Биеийн тамир спортын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт орлогын 357,352.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,573.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 610,968.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,109.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Биеийн тамир спортын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 121,701.8 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,552.0	752.0	-1,800.0
Авлага	465.8	14,056.6	13,590.8
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	67,544.0	68,577.3	1,033.3
Үндсэн хөрөнгө	7,134,264.3	6,999,738.4	-134,525.9
Нийт хөрөнгө	7,204,826.1	7,083,124.3	-121,701.8
Өр төлбөр	0	545.07	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,204,826.1	7,082,579.2	-122,246.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,204,826.1	7,083,124.3	-121,701.8

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 752.0 мянган төгрөг болж 1,800.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын баяр болон цагаан сарын баярыг угтан 9 ахмадад тусламж үзүүлснээс шалтгаалжээ. Энэ нь ахмадын сангийн дансны хуулганы үлдэгдлээр баталгаажиж байна.

Тайлант хугацааны авлагын үлдэгдэл 14,056.6 мянган төгрөг болж өмнө оноос 13,590.8 мянган төгрөгөөр өссөн нь 2020 оны 11 дүгээр сард зохиогдох байсан Эрдэнэт-Опен тэмцээн ковидын улмаас хойшлогдсон тул тэмцээний шүүгч, тамирчдын шагналаас суутгасан 208 мянган төгрөгийн татварын авлага, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс суутган тооцсон ХХОАТ-ын 262.8 мянган төгрөгийн татварын авлага, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир спортын газрын даргын А/97 дугаар цахим фитнес төслийг хэрэгжүүлэх тухай тушаалаар баталсан 13,120.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн дүнг төрийн сангийн гүйлгээ хаасны дараа буюу 12 дугаар сарын 28-ны өдөр тус байгууллагын дансанд шилжүүлсэн тул орон нутагт төвлөрүүлэн шилжүүлээд дараа онд авах авлага бий болгосноос шалтгаалжээ.

Авлага дансны эхний үлдэгдэлд 1995 онд арилжааны банкнууд дампуурах үед үүссэн удаан жилийн насжилттай, эрсдэлтэй 465.8 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь одоог хүртэл шийдэгдээгүй ба ирэх онд хуулийн байгууллагад шилжүүлэх хүсэлт гаргах гэж байгаа.

Бараа материалын дансны үлдэгдэл 68,577.3 мянган төгрөг болж 1,033.3 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд худалдан авалтаар 9,584.9 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, зарцуулалтаар 6,739.3 мянган төгрөгийн бараа материал буурч, байгууллагын даргын 2020 оны 12-р сарын 14 -ны өдрийн А/98 тушаалыг үндэслэн 1,892.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,999,804.7 мянган төгрөг болж 134,459.6 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь Орхон аймгийн Өмчийн харилцааны газрын 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 3/125 дугаар албан бичгийг үндэслэн 5,305.4 мянган төгрөгийн 2 ширхэг био нойл, мөн байгууллагын даргын А/45 тушаалаар Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яамнаас үнэ төлбөргүй шилжүүлсэн 33,600.0 мянган төгрөгийн УАЗ-фургон автомашинаар нэмэгдэж, Орхон аймгийн засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/757 дугаартай захирамжийн дагуу 6,620.8 мянган төгрөгийн хоккейн талбай болон 3,495.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 545.07 мянган төгрөг болж өссөн нь Эрдэнэт сангаас санхүүждэг Эрдэнэт соёл амралтын хүрээлэнгийн цахилгааны зардлын төлбөр хүрэлцээгүйгээс шалтгаалсан байна. Тус үлдэгдлийг харилцагч байгууллага болох Эрдэнэт Булганы ЦТСүлжээтэй тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,082,579.2 мянган төгрөг болж 122,246.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой.

Орхон аймгийн Биеийн тамир спортын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 534,150.0 мянган төгрөгөөр буюу 47 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь ковид-19 хөл хорионы улмаас тус байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого эрс буурсантай холбоотой.

Нийт зардал өмнөх оноос 11,883.78 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь ковид-19 хөл хорионы улмаас тэмцээн уралдаан зохион байгуулагдаагүй, хангамж бараа материал бага зарцуулагдсан зэрэгтэй холбоотой байна.

	2019.12.31	2020.12.31	Зөрүү
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	251,804.13	280,671.42	28,867.29
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,412.80	35,790.19	4,377.39
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,712.93	22,330.99	2,618.06
Хангамж, бараа материалын зардал	24,220.61	7,074.33	(17,146.27)
Нормативт зардал	475.90	-	(475.90)
Эд хогшил, урсгал засварын зардал	16,723.15	2,470.48	(14,252.67)
Томилолт, зочны зардал	1,700.00	-	(1,700.00)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,183.55	8,090.95	2,907.40
Бараа үйлчилгээний бусад зардал	298,741.77	281,662.69	(17,079.08)
Нийт дүн	649,974.83	638,091.06	(11,883.78)

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 384,548.5 мянган төгрөгөөр баталсан байна. Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 284,519.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 21,213.3 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 6,340.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 4,300.0 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 1,485.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 7,502.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 22,572 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөр 369,545.2 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 8,192.9 мянган төгрөг, нийт 377,738,1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 369,016,7 мянган төгрөгийг зарцуулж 8,721.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргыг нөөц сангаас Орхон аймагт зохион байгуулагдах спортын уралдаан тэмцээний үйл ажиллагааны зардалд хуваарилсан 178,025.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 15,620.0 мянган төгрөгийн санхүүжилт авч төрийн сангаас зарцуулах эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна. Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого 599.5 мянган төгрөгийг төвлөрүүлж Сангийн сайдын 225 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.2, 44-р зүйлийн 44.1.1 дэх заалтын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчаар төлөвлөгөөг батлуулан зарцуулах эрхийн дагуу цалин хөлстэй холбоотой зардалд 32,298.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 700 мянган төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 2,000.0 мянган төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардалд 98,138.6 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулалд 35,988.5 мянган төгрөгийг зарцуулж 25,118.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 134 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 7 мэдээлэл, иж бүрэн бус мэдээлсэн 1 мэдээлэл байна. Тайлант онд нийт 22 удаагийн 359.5 мянган төгрөгийн тушаалыг дутуу мэдээлсэн зөрчилтэй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Орхон аймгийн Төрийн аудит нь Биеийн тамир, спортын газрын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн шалгалтаар дараах зөрчил илрүүлсэн байна. Үүнд:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	632.13	1	632.13	1		100
Албан шаардлага	1	5,576.5	1	5,576.5	1		100
Нийт дүн	2	6,208.63	2	6,208.63	2		100

Шалгалтаар илэрсэн зөрчлийн 632.1 мянган төгрөгийг 2020 оны 06 дугаар сарын 11-ны өдрөөс өмнө хүү торгуулийн орлогын 100210000988 тоот дансанд шилжүүлсэн. Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 374,700.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 432.20 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 47.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 374,221.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Төлбөрийн акт, албан шаардлага

1. Үндсэн үйл ажиллагааны орлогын бүртгэл хангалтгүй, хяналтгүй байсан учраас аудитын гүйцэтгэлийн үе шатанд 2 өдрийн бүртгэлийн дагуу камер шүүж биет шалгалтыг хийхэд өөрийн орлогыг дутуу тайлагнадаг болох нь харагдаж байна. Шалгалтанд хамрагдсан өдөрт 47.0 мянган төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 41.2.1-т “бүх шатны төсвийн захирагч нь хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, НББ-ийн тухай хуулийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэн”, 14.4.5-т “бүх орлого” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

2. Ажиллагсдын цалинг тооцоолохдоо хоёр хөгжлийн бэрхшээлтэй ажилтны орлогоос 1-4 сард 262.8 мянган төгрөгийн ХХОАТ илүү суутган тооцоолсон нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1.2. “ хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлнө” гэсэн заалттай нийцэхгүй байна. Мөн нэг ажилтны амралтын мөнгийг тооцохдоо хөгжлийн бэрхшээлтэй хүнд нэмж олгох хоногийг тооцоогүй 169.4 мянган төгрөгийг дутуу бодож олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79.3 "18 насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" 79.5-т "Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан үндсэн амралт дээр нь дор дурдсан нэмэгдэл амралт олгоно" гэсэн заалттай зөрчилдөж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Орхон аймгийн Биеийн тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн жилд тухайн байгууллага үндсэн үйл ажиллагааны орлогоо хэрхэн бүртгэж, хяналт тавьж байгаа талаар анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: 8 сард ажилчдын амралтын мөнгийг бодохдоо нэг ажилтны 500.0 мянган төгрөгийн цалинд 120.0 мянган төгрөгийн нийгмийн даатгал тооцоогүй байна.
2. Эрсдэл: Ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг буруу тайлагнах
3. Өгсөн зөвлөмж: Цалинг тооцоолохдоо холбогдох тайлангуудтай тулган тайлангуудын уялдаа холбоонд хяналт тавьж ажиллах. Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 17.1.3

“нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах” гэсэн заалтуудын дагуу тайланг үнэн зөв гаргах

4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: 2021 оны 03-р сарын 05-ны өдрийн 3/34 тоот албан тоотоор хариу ирүүлсэн.

2. Дотоод хяналт, дүрэм журамтай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: 2020 онд Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө батлагдсан боловч тайлангийн хугацаанд санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй, мөн байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ зэрэг нь 2017 оноос хойш шинэчлэгдээгүй байна.
2. Эрсдэл: Байгууллагын дотоод үйл ажиллагаа хяналтгүй болж, алдаа зөрчил гарах.
3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэсэн заалтын дагуу байгууллагад мөрдөгдөх дотоод хяналтын бодлого, зохион байгуулалтыг боловсруулан дагаж мөрдөж ажиллуулах
4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: 2021 оны 03-р сарын 05-ны өдрийн 3/34 тоот албан тоотоор хариу ирүүлсэн.

3. Зардлын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Шилэн дансанд тайлангийн хугацааны мэдээллийг 7 талбарт хугацаа хоцроон мэдээлсэн, Иж бүрэн бүрэн бус 1 талбар дээр 22 удаагийн 359,500.0 мянган төгрөгийн тушаалыг дутуу мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2-т “Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
2. Эрсдэл: Мэдээлэл хэрэглэгчийн буруу мэдээллээр хангах, төсвийн ил тод байдал хангагдахгүй байх.
3. Өгсөн зөвлөмж Шилэн дансны тухай хууль, журмын дагуу мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, дотоод хяналт хэрэгжүүлэх.
4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: 2021 оны 03-р сарын 05-ны өдрийн 3/34 тоот албан тоотоор хариу ирүүлсэн.

4. Балансын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Тайлангийн хугацааны эцэст 14,056.6 мянган төгрөгийн авлага, 545.1 төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.
2. Эрсдэл: Санхүүгийн тайланд авлага, өглөг үүсгэх

Орхон аймгийн Биеийн тамир спортын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. Өвсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" заалтыг зөрчсөн байна.
4. Байгууллагаас өвсөн хариу тайлбар: 2021 оны 03-р сарын 05-ны өдрийн 3/34 тоот албан тоотгоор хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

Балтгэсэн:			
Аудитор		Б.Пүрэвсүрэн	Огноо
Анхан шатанд хянасан:			
Аудитын менежер		Б.Эрдэнэ	Огноо 
Хоёр дахь шатанд хянасан:			
Дарга, тэргүүлэх аудитор		Ц.Нармандах	Огноо

